БАТЛАВ: ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Х.ЭНХЦЭЦЭГ

1220100006
ЛУ32324 9051449

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- Барилга угсралтын ажил гүйцэтгэх үе шатны график
- Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийх фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэнэ.
Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. Барилгын норм ба дүрмийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Сүхбаатар аймгийн Асгат суманд үүсэх шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн ажил.

Нэгдүгээр зүйл: 10 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил, 2,709 метр

Хоёрдугаар: 250 кВА 10/0.4 кВ-ын АТП

Ажлын угсралтын явцад эвдэрсэн ногоон байгууламж, авто зам, явган хүний замыг сэргээн засварлана. Угсралтын ажлын явцад бусад инженерийн шугам сүлжээний огтлолцох, шугамын дагууд явах үед холбогдох байгууллагын инженер ажилчдыг байлгаж акт үйлдэж баталгаажуулна.

Угсралтын ажлыг эхлэхийг өмнө цэгүүдийн тэмдэгтийг дахин тогтоож өгөх ба холбох худгаас эхлэн шугамыг зурагт заасан налуутай угсрана. Газар шорооны ажлыг эхлэхийн өмнө холбогдох байгууллагаас зөвшөөрөл авна.

Угсралтын ажлын явцад Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм БНбД 12-04-06, БНбД 12-03-04 мөрдөх шаардлагатай.

Угсралтын ажлын зурагт заасан технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:
Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн **14.3-т "Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна",**

14.6-т "энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна" гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэгт өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Дээрхи техникийн тодорхойлтонд заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөл, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Боловсруулсан:

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ж.Батсуурь